



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/76/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал	14
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.ЧИНБАТ ТАНАА

2021.02.25 № 2/142

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

005020117

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,325,845.82	20,215,755.94
33	АВЛАГА	207,944.00	00.00
335	Бусад авлага	207,944.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	207,944.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,117,901.82	20,215,755.94
351	Түүхий эд материал	1,688,000.00	1,688,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,688,000.00	1,688,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,000,000.00	00.00
354	Хангамжийн материал	5,514,843.00	6,145,403.00
35410	Бичиг хэргийн материал	868,600.00	903,600.00
35420	Аж ахуйн материал	4,196,243.00	5,241,803.00
35450	Барилгын засварын материал	450,000.00	00.00
35600	Мал амьтад	35,915,058.82	12,382,352.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,147,920,438.19	1,290,850,055.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,147,920,438.19	1,290,850,055.97
392	Биет хөрөнгө	1,133,820,438.19	1,276,950,055.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,011,539,037.10	2,121,329,637.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,126,079,975.95	-1,185,558,746.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	178,184,244.68	155,334,244.68
39204	Хуримтлагдсан элэгдэл	-94,365,188.56	-88,485,111.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,493,797.00	107,021,670.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,196,059.13	-59,260,369.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,091,519.82	36,091,519.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,609,675.13	-21,864,289.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	177,642,230.00	304,959,173.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-78,520,781.64	-93,358,962.52
39217	Ном	641,290.00	741,290.00
393	Биет бус хөрөнгө	14,100,000.00	13,900,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,575,000.00	14,375,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-475,000.00	-475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,198,246,284.01	1,311,065,811.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	538,093.17	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	538,093.17	00.00
413	Өглөг	538,093.17	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	538,093.17	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,197,708,190.84	1,311,065,811.91
51	Засгийн газрын хувь оролцоо	1,197,708,190.84	1,311,065,811.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	398,727,817.78	398,727,817.78
51101	Өмч: - төрийн	398,727,817.78	398,727,817.78
512	Хуримтлагдсан үр дүн	587,483,969.82	700,841,590.89
51210	Өмнөх үеийн үр дүн	587,483,969.82	587,483,969.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	113,357,621.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	211,496,403.24	211,496,403.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,198,246,284.01	1,311,065,811.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	528,853,521.49	669,375,671.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	186,676,753.12	244,688,936.80
120	Нийтлэг татварын бус орлого	186,676,753.12	244,688,936.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	186,676,753.12	244,688,936.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,880.00	507,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	186,231,873.12	244,181,036.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	342,176,768.37	424,686,734.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,000.00	16,515,388.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,200,000.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,515,388.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,976,768.37	408,171,346.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,976,768.37	408,171,346.36
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	462,782,874.20	553,873,605.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,782,874.20	553,873,605.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,924,282.83	536,481,685.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,694,641.00	217,972,264.00
210101	Үндсэн цалин	186,694,641.00	217,972,264.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,143,706.17	28,426,603.83
210201	Тэтгэврийн даатгал	17,024,793.17	19,708,065.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,693,376.00	2,178,410.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,447,100.00	1,742,440.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,800.00	435,619.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,616,637.00	4,362,069.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,416,155.00	27,500,230.00
210301	Гэрэл, цахилгаан	5,787,445.00	8,138,066.00
210302	Түлш, халаалт	19,628,710.00	19,362,164.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,687,283.00	61,216,735.88
210401	Бичиг хэрэг	3,490,200.00	3,790,060.00
210402	Тээвэр, шатахуун	19,466,843.00	19,601,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	593,740.00	656,700.00
210404	Ном, хэвлэл	178,700.00	5,240,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	346,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	957,800.00	600,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	30,982,705.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,801,500.00	14,515,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,999,500.00	850,000.00
210604	Урсгал засвар	6,802,000.00	13,665,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,946,000.00	5,319,000.00
210701	Гадаад албан томилолт	2,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	6,787,000.00	5,319,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,159,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,265,568.00	51,066,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,984,800.00	46,624,933.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,160.00	593,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,908.00	179,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	24,908.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	130,700.00	79,256.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,994,429.66	130,465,804.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,947,482.18	19,455,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,199,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,946,947.48	109,811,354.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,833,591.37	17,391,920.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,435,000.00	990,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,435,000.00	990,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,848,591.37	16,401,920.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,848,591.37	16,401,920.36
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,550,000.00	00.00

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,550,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	66,070,647.29	115,502,065.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	176,056,538.07	2,144,444.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	176,056,538.07	2,144,444.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-176,056,538.07	-2,144,444.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-109,985,890.78	113,357,621.07

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	342,621,648.37	425,194,634.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	444,880.00	507,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	444,880.00	507,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	444,880.00	507,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,880.00	507,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	342,176,768.37	424,686,734.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,000.00	16,515,388.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,200,000.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,515,388.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,976,768.37	408,171,346.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,976,768.37	408,171,346.36
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	327,921,448.37	414,444,634.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,921,448.37	414,444,634.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,037,857.00	397,052,714.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,918,418.00	217,764,320.00
210101	Үндсэн цалин	186,918,418.00	217,764,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,605,613.00	27,832,099.00
210201	Тэтгэврийн даатгал	16,486,700.00	19,113,561.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,693,376.00	2,178,410.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,447,100.00	1,742,440.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,800.00	435,619.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,616,637.00	4,362,069.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,416,155.00	27,500,230.00
210301	Гэрэл, цахилгаан	5,787,445.00	8,138,066.00
210302	Түлш, халаалт	19,628,710.00	19,362,164.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,799,283.00	31,868,970.00
210401	Бичиг хэрэг	3,667,200.00	3,945,060.00
210402	Тээвэр, шатахуун	19,656,843.00	19,601,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	593,740.00	1,136,640.00
210404	Ном, хэвлэл	269,700.00	6,240,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	346,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	611,800.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,574,500.00	14,915,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,999,500.00	850,000.00
210602	Тавилга	929,000.00	400,000.00
210604	Урсгал засвар	8,646,000.00	13,665,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,225,000.00	5,319,000.00
210701	Гадаад албан томилолт	2,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	6,787,000.00	5,319,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,438,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,718,568.00	52,098,645.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,375,200.00	47,657,531.00
210803	Даатгалын үйлчилгээ	452,760.00	593,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129,908.00	179,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	24,908.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	130,700.00	79,256.00

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,780,320.00	19,754,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,680,320.00	18,555,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,199,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,883,591.37	17,391,920.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,485,000.00	990,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,485,000.00	990,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,398,591.37	16,401,920.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,848,591.37	16,401,920.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,700,200.00	10,750,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,700,200.00	10,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,700,200.00	10,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,700,200.00	10,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,700,200.00	10,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,700,200.00	-10,750,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	211,496,403.24	697,469,860.60	1,307,694,081.62
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-109,985,890.78	-109,985,890.78
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	211,496,403.24	587,483,969.82	1,197,708,190.84
D01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	211,496,403.24	587,483,969.82	1,197,708,190.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,727,817.78	211,496,403.24	587,483,969.82	1,197,708,190.84
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	113,357,621.07	113,357,621.07
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	211,496,403.24	700,841,590.89	1,311,065,811.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,061,304.00	392,277,326.00	35,783,978.00	91.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,061,304.00	392,277,326.00	35,783,978.00	91.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,561,304.00	391,287,326.00	35,273,978.00	91.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,085,800.00	217,764,320.00	11,321,480.00	95.1%
210101	Үндсэн цалин	229,085,800.00	217,764,320.00	11,321,480.00	95.1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,926,600.00	27,832,099.00	3,094,501.00	90.0%
210201	Тэтгэврийн даатгал	21,763,136.00	19,113,561.00	2,649,575.00	87.8%
210202	Тэтгэмжийн даатгал	2,290,860.00	2,178,410.00	112,450.00	95.1%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,832,712.00	1,742,440.00	90,272.00	95.1%
210204	Ажилгүйдлийн даатгал	458,160.00	435,619.00	22,541.00	95.1%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,581,732.00	4,362,069.00	219,663.00	95.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,286,104.00	27,500,230.00	785,874.00	97.2%

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	8,794,900.00	8,138,066.00	656,834.00	92.5%
210302	Түлш, халаалт	19,491,204.00	19,362,164.00	129,040.00	99.3%
2104	Хангамж, бараа материалын зардал	35,580,800.00	31,868,970.00	3,711,830.00	89.6%
210401	Бичиг хэрэг	4,228,600.00	3,945,060.00	283,540.00	93.3%
210402	Тээвэр, шатахуун	21,142,500.00	19,601,170.00	1,541,330.00	92.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,349,700.00	1,136,640.00	213,060.00	84.2%
210404	Ном, хэвлэл	7,900,000.00	6,240,100.00	1,659,900.00	79.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	346,000.00	14,000.00	96.1%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	0.00	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,945,700.00	25,665,000.00	-719,300.00	102.9%
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0%
210602	Тавилга	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0%
210604	Урсгал засвар	12,945,700.00	13,665,000.00	-719,300.00	105.6%
2107	Томилолт, зочны зардал	10,046,600.00	5,319,000.00	4,727,600.00	52.9%
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00	00.00	1,000,000.00	0.0%
210702	Дотоод албан томилолт	9,046,600.00	5,319,000.00	3,727,600.00	58.8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,926,600.00	35,583,257.00	13,343,343.00	72.7%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,349,900.00	31,142,143.00	13,207,757.00	70.2%
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	593,450.00	6,550.00	98.9%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	179,500.00	500.00	99.7%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,000.00	24,908.00	77,092.00	24.4%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0%
210807	Газрын төлбөр	130,700.00	79,256.00	51,444.00	60.6%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18763100.00	19754450.00	-991,350.00	105.3%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,563,100.00	18,555,000.00	-991,900.00	105.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,199,450.00	550.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1500000.00	990000.00	510,000.00	66.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	990,000.00	510,000.00	66.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	990,000.00	510,000.00	66.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	428,061,300.00	392,277,326.00	35,783,974.00	91.6%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	427,061,300.00	391,769,426.00	35,291,874.00	91.7%
132001	Орон нутгийн төсвөөс	427,061,300.00	391,769,426.00	35,291,874.00	91.7%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	507,900.00	492,100.00	50.8%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	507,900.00	492,100.00	50.8%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13.00	13.00	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00	0.00	100.0%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	07.00	07.00	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	16,515,388.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	16,515,388.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	16,515,388.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	16,515,388.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	16,515,388.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	16515388.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	16,515,388.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,515,388.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга М.Чинбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 11 дугаар сарын 02-ны өдрийн 2/92 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Төрийн захиргааны нэгдмэл удирдлагыг хангаж, төрийн мэргэшсэн албан хаагчаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхайн үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй мэдээлж хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 342257.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6845.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 556018.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11120.4 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1311065.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 112819.5 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,325.8	20,215.8	(30,110.1)
Авлага	207.9	-	(207.9)
Бараа материал	50,117.9	20,215.8	(29,902.1)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,147,920.4	1,290,850.1	142,929.6
Үндсэн хөрөнгө	2,513,167.1	2,739,852.5	226,685.4
Хуримтлагдсан элэгдэл	(1,365,246.7)	(1,449,002.5)	(83,755.8)
Нийт хөрөнгө	1,198,246.3	1,311,065.8	112,819.5
Өр төлбөр	538.1	-	(538.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,197,708.2	1,311,065.8	113,357.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,198,246.3	1,311,065.8	112,819.5

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх оны ХХОАТ-ын авлага 207.9 мянган төгрөгийг 2020 оны тооцооноос суутган тооцоо хийж авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20215.8 мянган төгрөг болж 29902.1 мянган төгрөгөөр буурсан нь ОНХС-гийн хөрөнгөөр дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээг дуусаагүй үйлдвэрлэл дансанд 7000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг зарлагадан хөрөнгөд орлого авсан, жилийн эцсийн мал тооллогоор хорогдсон 23532.7 мянган төгрөгийн малыг /улсын байцаагчийн дүгнэлт, тухайн байгууллагын даргын шийдвэргүй/ акталж устгасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2739852.5 мянган төгрөг болж 226685.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын Засаг даргын А/165, А/119, А/166, А/167 тоот захирамжуудыг үндэслэн сумын ОНХС-гийн хөрөнгөөр 23700.0 мянга, сумын хүндэтгэлийн хаалгыг сумын Засаг даргын захирамжаар ОНХС-гаас 8000.0 мянга, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив 89190.0 мянга нийт 90190.6 мянган төгрөгөөр хийж хөрөнгөд орлого авсан, мөн аймгийн ИТХ-ын тургүүлэгчдийн 2020 оны 121 тоот тогтоолыг үндэслэн 15 кв 160 дэд станц, ЦДАШ 103816.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авсантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.01.21-ны өдрийн 03 тоот тогтоолоор 28000.0 мянган төгрөгийн Ланд 80 автомашин акталж аймгийн Орон нутгийн өмчийн газарт сэлбэгээр ашиглуулах тогтоол гарсны дагуу тус автомашиныг данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1311065.8 мянган төгрөг болж 113357.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 113357.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 669375.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 140522. мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна.

Энэ нь төсөвт байгууллагын үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 57949.2 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 69194.6 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан санхүүжилт 13315.4 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 553873.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 91115.7 мянган төгрөгөөр буюу 19.67 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 31277.6 мянга, НДШ 4282.9 мянга, хангамж бараа материалын зардал 36229.4 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 2084.1 мянга, хангамж, бараа материалын зардал 53216.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 27800.5 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 430500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 430500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 413198.2 мянган төсөв батлагдаж 1 удаа тодотгол хийн 428061.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 427061.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 428061.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 392277.3 мянган төгрөгийг зарцуулж 35783.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 392277.3 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа цалин 11321.5 мянга, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр 13343.3 мянга, хангамж, бараа материалын данс 3711.8 мянга, томилолт 4727.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Мал тооллого 957.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан, ажил үйлсээрээ шалгарч аймгийн Засаг даргаас 12000.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал авсныг сумын төсөвт байгууллагын ажиллагсдыг шагнаж урамшуулж, сумын ЗДТГ-ын ажилчдад спортын бэлтгэлийн хувцас хийж олгосон байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 16 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 103630.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	103630.0	2	103630.0			
Нийт дүн	2	103630.0	2	103630.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 54974.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23292.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 31682.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 23292.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд Сум дундын ойн ангиас ирсэн 23292.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 11,12 сард хүлээн авч, мөнгийг бүрэн шилжүүлсэн боловч тус өвсийг бараа материалын дансанд орлого зарлагаар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалт, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сум дундын ойн ангиас олгосон өвс тэжээлийн тооцоог 2021.03.15-ны дотор нийлж, үлдэгдэл тооцоог баталгаажуулан данс бүртгэлд тусган биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 31682.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.01.21-ны өдрийн 03 тоот тогтоолоор акталсан 28000.0 мянган төгрөгийн Ланд 80 автомашиныг Орон нутгийн өмчийн газар сэлбэгээр орлого авч ашигласан эсэхийг тодруулж үзэх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Сумын ИТХ-ын 2020.09.29-ны өдрийн 17/4 тоот хурлын хуралдааны тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулсан ба тус өөрчлөлтөөр урсгал засварт 4000.0 мянган төгрөг батлагдсаныг 12250.0 мянган төгрөг болгон тодотгон баталж Баянцагаан сумын ЗДТГ-т бүртгэлтэй 73-24 БНА улсын дугаартай TLC 200 автомашинд 7336.2 мянган төгрөгийн засвар үйлчилгээ, 813.7 мянган төгрөгийн зогсоолын төлбөр төлсөн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 59800.0 мянган төгрөгөөр хуучин ашиглаж байсан автомашиныг худалдан авч 3 жилийн дотор их засварт орж төсөвт их хэмжээний зардал үүсгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй

1.3. Өгсөн зөвлөмж:

- Байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр дахин хэлэлцүүлж буруутай этгээдээр TLC 200 автомашин засвар үйлчилгээ, зогсоолын төлбөр 8149.9 мянган төгрөгийг төлүүлж төсөвт учирсан хохирлыг арилгах
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ, судалгаа шинжилгээний үндсэн дээр хөрөнгө оруулалтын захиалгыг өгөөгүйгээс хуучин автомашин худалдан авснаас төсөвт засвар үйлчилгээний нэмэгдэл их хэмжээний зардал гаргаж сумын ИТХ-аар батлуулж төсөвт хүндрэл учруулж байгааг зогсоох.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Дахин хэлэлцүүлэх

2.1. Илрүүлэлт: Жилийн эцсийн тооллогоор 23532.7 мянган төгрөгийн хорогдсон малыг мал эмнэлгийн дүгнэлт гараагүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй данснаас хассан, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга, хэмжээг орлого авахдаа сумын Засаг даргын захирамжийг үндэслэн хөрөнгө орлого авсан нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5.1.4.үнэн зөв байх; 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2 "Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн

эрхтэй: 1/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;" гэсэн заалт, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна:

2.2. Эрсдэл: Хөрөнгө дутагдах

2.3. Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн тооллогоор хорогдсон малыг мал эмнэлгийн улсыг байцаагчийн дүгнэлт, тус байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, ЗДТГ-ын даргын тушаалыг үндэслэн данснаас хасах, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг орлого авахдаа ажил хүлээн авсан комиссын актыг үндэслэн сумын ИТХ-ын "хөрөнгө орлого авах" тогтоол гаргуулж санхүүгийн тайланд орлогоор бүртгэж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 16 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

2.2. Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.АЛТАНТУЯА 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН,
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН,
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянцагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/76/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянцагаан сумын ЗДТГ		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сумын ИТХ-ын 2020.09.29-ны өдрийн 17/4 тоот хурлын хуралдааны тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулсан ба тус өөрчлөлтөөр урсгал засварт 4000.0 мянган төгрөг батлагдсаныг 12250.0 мянган төгрөг болгон тодотгон баталж Баянцагаан сумын ЗДТГ-т бүртгэлтэй 73-24 БНА улсын дугаартай TLC 200 автомашинд 7336.2 мянган төгрөгийн засвар үйлчилгээ, 813.7 мянган төгрөгийн зогсоолын төлбөр төлсөн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 59800.0 мянган төгрөгөөр хуучин ашиглаж байсан автомашиныг худалдан авч 3 жилийн дотор их засварт орж төсөвт их хэмжээний зардал үүсгэж байна.	8150.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
2	Тайлант онд Сум дундын ойн ангиас ирсэн 23292.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг 11,12 сард хүлээн авч, мөнгийг бүрэн шилжүүлсэн боловч тус өвсийг бараа материалын дансанд орлого зарлагаар бүртгээгүй байна.	23292.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
3	Жилийн эцсийн тооллогоор 23532.7 мянган төгрөгийн хорогдсон малыг мал эмнэлгийн дүгнэлт гараагүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй данснаас хассан, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга, хэмжээг орлого авахдаа сумын Засаг даргын захирамжийг үндэслэн хөрөнгө орлого авсан.	23532.7	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 16 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Чинбат, Г.Түмэнболд
ДҮН		54974.7			

_____оОо_____